



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

”Урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой
үйл ажиллагааг тодорхойлох заавар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.1, 14.2.20, 49.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1.”Урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэнэ)-ноос Даатгалын тухай хуулийн 14.1, 14.2.20, 49.2-д заасны дагуу урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани (цаашид “Урт хугацааны даатгагч” гэх)-ийн урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урт хугацааны даатгагч нь Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт зөвхөн урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг эрхэлнэ.

1.3. Даатгалын тухай хуулийн 16.1-д заасны дагуу дор дурдсанаас бусад этгээд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1.3.1. Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд;

1.3.2. Даатгалын тухай хуулийн 17.2-т заасан гадаадын даатгагч тухайлбал, Ллойдын андеррайтерын холбоонд багтдаг даатгагч.

ХОЁР. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа

2.1. “Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа” гэж даатгагч, даатгуулагч нар гэрээний дагуу харилцан тохиролцож, даатгуулагч нас барахад, эсхүл тодорхой цаг хугацааны эцэст даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөлөөр хангаж буй хүний амьдралыг даатгах үйл ажиллагааг ойлгоно.

2.2. Урт хугацааны даатгагч нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж үл болно.

2.3. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамааруулна:

2.3.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон урт хугацааны даатгалын хэлбэрүүдээр даатгалын гэрээ болон даатгалын баталгаа боловсруулж гаргах;

2.3.2. Монгол Улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасны дагуу даатгалын гэрээ байгуулах, гэрээг сунгах, өөрчлөх;

2.3.3. Даатгалын гэрээг бусдад шилжүүлэх, цуцлах;

2.3.4. Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу даатгалын нөхөн төлбөр төлөх;

2.3.5. Даатгалын эрсдэлийн болон хохирлын тойм үнэлгээ хийх;

2.3.6.Хорооны 2008 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын нөөцийн санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу даатгалын нөөцийн сан байгуулах;

2.3.7.Даатгалын хураамжийг Хорооны 2008 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ын дагуу тооцож, үүнтэй холбоотой актуарын тооцоолол хийх;

2.3.8.Хорооны 2007 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрийн жагсаалт”-д заасан даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр журам боловсруулах;

2.3.9.Даатгалын эрсдэлээ давхар даатгуулах, түүнтэй холбоотой үүсч болох бусад үйл ажиллагаа явуулах;

2.3.10.Даатгалын компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах зэрэг даатгалын үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулах.

ГУРАВ. Урт хугацааны даатгалтай холбоотой үйл ажиллагаа

3.1.Даатгагчийн дараах үйл ажиллагааг урт хугацааны даатгалтай холбоотой үйл ажиллагаанд хамааруулна:

3.1.1.Хорооны 2008 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага”-д заасан хөрөнгө оруулалтын дараах үйл ажиллагаа:

3.1.1.1.Засгийн газрын өрийн бичиг худалдан авах;

3.1.1.2.Төв банкны үнэт цаас худалдан авах;

3.1.1.3.Банкинд мөнгөн хөрөнгө хадгалуулах;

3.1.1.4.Орон нутгийн засаг захиргааны бонд худалдан авах;

3.1.1.5.Банкны хадгаламжийн сертификат худалдан авах;

3.1.1.6.Компанийн бонд худалдан авах;

3.1.1.7.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах;

3.1.1.8.Банкны харилцах дансанд мөнгөн хөрөнгө байршуулах;

3.1.1.9.Түрээсийн үйл ажиллагаа явуулах.

3.1.2.Энэ журмын 3.1.1-д заасан хөрөнгө оруулалтыг удирдах, захиран зарцуулах;

3.1.3.Даатгалын салбар, төлөөлөгчийн газар нээж ажиллуулах;

3.1.4.Даатгалын зөвлөгөө өгөх, сургалт явуулах;

3.1.5.Даатгалын компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;

3.1.6.Даатгалын компанийн байрны засвар үйлчилгээ хийх, түүнийг худалдах, худалдан авах;

3.1.7.Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлд зааснаас бусад даатгалын зар сурталчилгаа явуулах;

3.1.8.Холбогдох хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхлэх.

3.2.Дараах үйл ажиллагаа нь урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарахгүй:

3.2.1.Ердийн даатгалын үйл ажиллагаа;

3.2.2.Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа;

3.2.3.Ердийн даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа;

3.2.4.Даатгалын аудитын үйл ажиллагаа;

3.2.5.Энэ журмын 2, 3 дугаар хэсэгт зааснаас бусад үйл ажиллагаа.

ДӨРӨВ. Хариуцлага

4.1.Даатгалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасныг зөрчсөн буюу энэ зааврын 2.3, 3.1-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлсэн даатгагчид Даатгалын тухай хуулийн 83.1.19-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--